



**GRATA**  
INTERNATIONAL

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

[www.gratane.com](http://www.gratane.com)

## 1. Уул уурхайн салбарын судалгаа

### Танилцуулга:

Монгол Улсын газар нутаг нь Төв Азийн уул өргөгдсөн бүсийн төвд Зүүн Европ, Сибирь, Хойд Хятад, Тарим хавтангуудын хил заагт оршдог төдийгүй Фанерозойн үүссэн хамгийн том эх газрын царцдас юм. Монгол улс байгалийн асар их нөөц, хөдөө аж ахуйн өргөн боломжтой, Азийн томоохон зах зээл болсон улс орнуудтай хөрш газарзүйн байрлалтай учир дунд болон урт хугацааны гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) оруулах таатай орчин болно. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2023 оны эхний хагас жилд 30,5 их наяд төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 7,1 (30.6%) их наяд төгрөгөөр өссөн байна. ДНБ нэмэгдэхэд уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 3,7 (69.4%) их наяд төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг өмнөх оны мөн үеэс 2,3 (24.0%) их наяд төгрөгөөр өссөн нь тус тус нөлөөлжээ.[1]

Монгол Улсын Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалт ихээр татаж байгалийн эрдэс баялаг, ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглахыг зорьж ажиллаж байна. Доорх диаграмд харуулснаар Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 79.4 хувь нь уул уурхайн салбарт, үлдсэн хувь нь Худалдаа, Хүнс, Банк ба санхүүгийн байгууллага болон бусад салбаруудад оруулсан байна.



Үндэсний статистикийн хороо (<https://www.1212.mn/mn>), 2023

ДНБ-ий салбарын бүтцийг өмнөх оныхтой харьцуулбал, уул уурхай, олборлолтын салбарынх 6.8 нэгж хувиар нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарынх 3.1 нэгж хувиар, бүтээгдэхүүний цэвэр татвар 1.5 нэгж хувиар, аж үйлдвэр, барилгынх 0.2 нэгж хувиар тус тус буурсан байна.

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

Дэлхийд тэргүүлэгч эрдэс баялгийн нөөцтэй гэж тооцогддог орнуудын нэг болох Монгол Улс нь 1170 уурхайд 8000 гаруй илрэл, 80 төрлийн ашигт малтмал, металлын нөөцтэй бөгөөд зэс, үндсэн металл, алт, нүүрс, ураны өндөр нөөцтэй гэж тооцогддог [2].

## Бүртгэгдсэн нөөц эрдэс баялаг [3]

№	Ашигт малтмал	Нэгж	Нэгж
1	Зэс	Сая тонн	61.4
2	Нүүрс	Тэрбум тонн	34.6
3	Төмрийн хүдэр	Тэрбум тонн	1.84
4	Алт	Тонн	499.5
5	Цайр	Сая тонн	4.7
6	Жонш	Сая тонн	34.2
7	Уран	Мянган тонн	192.2
8	Газрын тос	Сая тонн	333.8

Монгол оронд хийгдсэн геологийн судалгааны үр дүнд хүдэржилтийн 11 бүс газрыг ялгаж 30 гаруй орд, 200 гаруй илрэл тогтоогдсон байна.

Монгол орны нутаг дэвсгэрт төмрийн хүдрийн 14 бүс ялгагдсан байдаг. Нийтдээ 250 орчим орд, илрэл, эрдэсжсэн цэг илрүүлсэн.

Монгол улс дэлхийн нийт нүүрс олборлолтын 0.5%-ийг эзэлж байна.

Цайрын нийт нөөц дэлхийн нийт нөөцийн 2.2%-ийг эзэлж байна.

Ураны нийт бүртгэгдсэн нөөц дэлхийн нийт нөөцийн 3.2%-ийг эзэлж байна.

Монгол орны хэмжээнд алтны нийт бүртгэгдсэн нөөц 499.5 тн (Оюутолгойн ордын дагалдах алтны нөөцийг оруулахгүйгээр) байгаа нь нийт нөөцийн 1%-ийг эзэлж байна.

[2] <https://investmongolia.gov.mn/metals-and-mining/>

[3] Эрдэс баялгийн салбарын товч мэдээлэл /2023-2024/, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, 2023

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023



2023 оны эхний 7 сарын байдлаар улсын төсөвт 4,102.6 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс 2,000.4 тэрбум төгрөг буюу 95.2 хувиар өссөн байна. [4] Үүнээс:

<b>Нүүрс</b>	2,489.1 тэрбум төгрөг
<b>Алт</b>	138.4 тэрбум төгрөг
<b>Цайр</b>	107.5 тэрбум төгрөг
<b>Төмөр</b>	49.2 тэрбум төгрөг
<b>Хайлуур жонш</b>	15.8 тэрбум төгрөг
<b>Бусад ашигт малтмал</b>	64.8 тэрбум төгрөг

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

<b>Нүүрс</b>	1,769.8 (3.5 дахин) тэрбум төгрөг
<b>Зэс</b>	163.6 (15.2%) тэрбум төгрөг
<b>Алт</b>	4.8 (3.6%) тэрбум төгрөг
<b>Цайр</b>	14.3 (15.4%) тэрбум төгрөг
<b>Төмөр</b>	22.2 (82.0%) тэрбум төгрөг
<b>Хайлуур жонш</b>	2.4 (18.0%) тэрбум төгрөг
<b>Бусад ашигт малтмал</b>	23.3 (55.9%) тэрбум төгрөг

## Эрдэс баялгийн салбарын үр нөлөө



Үндэсний статистикийн хороо, Монголбанк

[4] Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл /2023 оны 1-7 сар/ -<https://mmhi.gov.mn/2023/09/25/%d1%8d%d1%80%d0%b4%d1%8d%d1%81-%d0%b1%d0%b0%d1%8f%d0%bb%d0%b3%d0%b8%d0%b9%bd-%d1%81%d0%b0%d0%bb%d0%b1%d0%b0%d1%80%d1%8b%d0%bd-%d1%81%d1%82%d0%b0%d1%82%d0%b8%d1%81%d1%82%d0%b8%d0%ba-%d0%bc%d1%8d-17/>

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

## 2. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж нь дараах хуулиудаас бүрдэнэ:

Хуулийн нэр	Зохицуулах харилцаа
<b>Ашигт малтмалын тухай хууль</b>	<p>Ашигт малтмалын тухай хууль нь эрдэс баялгийн салбарын гол хууль бөгөөд дараах онцлог зохицуулалтуудыг агуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1.Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлж, ажлын байр нэмэгдүүлсэн.</li><li>2.Засгийн газраас хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх болсон.</li><li>3.Геологийн салбарт баримтлах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх зорилт бүхий геологийн судалгаа, шинжилгээ, мэдээлэл хариуцсан Үндэсний геологийн алба байгуулахаар тусгасан.</li><li>4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгоход тэргүүн ээлжид Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжид давуу эрх олгодог байхаар зохицуулсан.</li><li>5.Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжид, зах зээлийн үнээр нийлүүлэхийг зааж өгсөн.</li><li>6.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулахаар заасан.</li><li>7.Ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээний дагуу хүртэх ногдол ашигтай дүйцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тусгай нөөц ашигласны төлбөрийн хэлбэрээр орлуулан авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн.</li></ol>
<b>Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль</b>	<p>Түгээмэл тархацтай ашигт малтмал гэж зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий элс, хайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайрганы зориулалттай барилгын чулууны хуримтлалыг хэлнэ.</p> <p>Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл авах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулна.</p>

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

<b>Газрын тосны тухай хууль</b>	Газрын тосны тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосыг эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн хууль юм.
<b>Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль</b>	Энэ хуулийн зорилт нь газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад орших бөгөөд газрын тосны бүтээгдэхүүн гэж газрын тос болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гаргаж авсан бүх төрлийн шатахуун, тусгай шингэн, шатдаг хий, тос тослогоо материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг хэлдэг байна.
<b>Цөмийн энергийн тухай хууль</b>	Цөмийн энергийн тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

## Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль

Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг шударга, нээлттэй ил тод зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох боломжийг хангах, экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах замаар уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд энэ салбарын оруулах хувь нэмрийг улам өргөжүүлэх шаардлагад үндэслэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг УИХ-аас баталж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн юм.

Уг хуулийн зорилт нь уул уурхайн бүтээгдэхүүний биржийг үүсгэн байгуулах, биржийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тогтоож биржийн арилжааг зохион байгуулах, хяналт тавих, биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүргийг тодорхойлох, эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

## Биржээр арилжаалах бүтээгдэхүүн

№	Бүтээгдэхүүний нэр	Төрөл
1.	Хайлуур жонш	Хүдэр
		Баяжмал

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

2.	Төмөр	Хүдэр
		Баяжмал
3.	Нүүрс	Боловсруулаагүй
		Баяжуулсан

Дээрх уул уурхайн бүтээгдэхүүнийг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд борлуулах тохиолдолд, заавал биржээр арилжина.

Биржээр бүтээгдэхүүнийг арилжаалахад (i) спот гэрээ; (ii) форвард гэрээ; (iii) фьючерсийн гэрээ; эсхүл (iv) опцион гэрээ байгуулах бөгөөд биржийн арилжаа хийгдэж, хэлцэл биелснээр арилжааны гэрээг байгуулсанд тооцно.

Биржээр арилжаалах бүтээгдэхүүний чанар, стандарт нь худалдан авагчаас шаардсан чанар, стандартад нийцэж байгаа эсэхэд бирж хяналт тавина.

Биржийн арилжааны үнийг хил залгаа улсын хилийн боомтын үнээр зарлана. Биржийн арилжааны явцад талууд биржээс зарласан үнийг зөвшөөрснөөр гэрээний үнэ тогтоно.

Биржийн арилжаатай холбоотой гомдол гаргах бол арилжаа хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн дэргэдэх маргаан таслах зөвлөлд гаргана. Маргаан таслах зөвлөл нь гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

## Тусгай зөвшөөрөл

Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах эрх бүхий этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд	Тусгай зөвшөөрөл
Засгийн Газар	газрын тос борлуулах зориулалт бүхий дамжуулах хоолой барих
	үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх
	хүн амын эрүүл мэнд, мал, ан амьтан, байгаль орчинд онцгой нөлөө бүхий хортой бодисыг хамгаалан булахад зориулан газрын хэвлийг ашиглуулах

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	бүх төрлийн шатахууны бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэх
	бүх төрлийн шатахууныг импортлох
	газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх
	газрын тос, уламжлалт бус газрын тос хайх, ашиглах
Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах
	үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил явуулах
	үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх
Хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх
	үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх
Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тосны хураагуурын орон зайд газрын тос хадгалах
Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	ашигт малтмал ашиглах
	ашигт малтмал хайх
	цацраг идэвхт ашигт малтмал ашиглах
	Цацраг идэвхт ашигт малтмал олборлосны дараа газрыг нөхөн сэргээх
Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, импортлох, экспортлох
	цацрагийн үүсгүүрийг угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах
	цацрагийн үүсгүүрийн хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх
	цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах
Цөмийн энергийн комисс	цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах
	цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлах
	цөмийн төхөөрөмж ашиглах
	цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах
Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга	ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглуулах
	түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах
	түгээмэл тархацтай ашигт малтмал хайх



# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

Монгол Улсын Их Хурал 2022 оны 6-р сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталсан бөгөөд үүнтэй холбогдуулан өмнө мөрдөгдөж байсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам хүчингүй болсон. Уг хуулийн дагуу:

- Тухайлсан эдийн засгийн үйл ажиллагааны салбарыг зохицуулж буй хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг **5 жилээс доошгүй хугацаатай** олгоно. Үүнээс үзвэл, одоо байгаа тусгай зөвшөөрлүүдийн хувьд тухайн салбарын хууль тогтоомжоороо зохицуулагдана.
- Татварын өргүй, байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулж, ажлын байраа хадгалсан зэрэг тодорхой нөхцөл шаардлагуудыг хангасан бол зөвшөөрлийн анх олгосон хугацааг хоёр дахин нэмэгдүүлж сунгах боломжтой.

Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл болон сунгуулах хүсэлт шийдвэрлэх журам	
Баримт бичгийн бүрдлийг шалгах	Ажлын 2 өдөр
Нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг магадлан шалгах	Ажлын 10 өдөр
Магадлан шалгах ажиллагааны хугацааг сунгах	Ажлын 5 өдөр
Шийдвэр гаргах	Ажлын 5 өдөр

- Хэрэв өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол нөхөн бүрдүүлэх 30 хоногийн хугацаа олгоно. Энэ хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж өгөөгүй бол өргөдөл гаргаагүйд тооцно.
- Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд тухайн зөвшөөрөл хүсэгч зургаан сарын дотор уг чиглэлээр дахин өргөдөл гаргах эрхгүй болно.

## **Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам.**

Засгийн газраас баталсан “хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол” –д сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгоно.

**Сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй этгээд:**

- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа;
- Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

Дээрх шаардлагыг хангасан этгээд нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:



- Тухайн хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, факсны дугаар, цахим шуудангийн хаяг;
- Тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Үйлчилгээний хөлс төлсөн баримт;
- Мэргэжлийн боловсон хүчин болон техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан талаархи мэдээлэл, тухайн талбайд гүйцэтгэх хайгуулын ажлын төрөл, хэмжээ, хугацаа, өртөг болон байгаль орчныг хамгаалах ажилд зарцуулах зардал бүхий төсөл, төсөв болон холбогдох бусад баримт бичгийг нэгтгэсэн техникийн санал;
- Төрийн захиргааны байгууллагын баталсан маягтын дагуу үйлдэж, битүүмжилж ирүүлсэн үнийн санал;
- Монгол Улсад татвар төлөгчөөр бүртгүүлсэн тухай татварын албаны тодорхойлолт;
- Сонгон шалгаруулалтын талбайн хэмжээнд ногдох босго үнэ төлсөн баримт.

Сонгон шалгаруулалтын комисс оролцогчдоос ирүүлсэн үнийн болон техникийн саналын үнэлгээний оноог нэгтгэж, хуралдааны тэмдэглэл үйлдэн, тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлтийг гаргана.

Сонгон шалгаруулалт зарласан боловч хүсэлт ирээгүй, эсхүл ирүүлсэн хүсэлт нь шаардлага хангаагүй бол сонгон шалгаруулалтыг дахин зарлана.


Сонгон шалгаруулалтын комисс нэгтгэсэн дүнг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад ажлын нэг өдөрт багтаан хүргүүлнэ.



Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдөрт багтаан холбогдох шийдвэрийг гаргана.



# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023



*Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө түүнийг эзэмшигч нь хугацааг сунгуулах тухай өргөдлийг төрийн захиргааны байгууллагад гаргана.*

## **Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох журам**

Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах эрхтэй.

**Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд** уурхайн талбайн булангийн цэгийг төрийн захиргааны байгууллагаас баталсан нэг загварын газрын зураг дээр тэмдэглэж, солбицлуудыг градус, минут, секундээр тодорхойлж хавсаргана.

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

Уурхайн талбай нь дараах шаардлагыг хангасан байна:



тал бүр тийш 500 метрээс багагүй урттай, уртраг, өргөргийн дагуух чиглэлтэй давхацсан шулуун шугамаар хүрээлэгдсэн тэгш олон өнцөгт хэлбэртэй


тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай давхцаагүй

давс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын тухайд талбайн хэмжээ нь тал бүр тийш 100 метрээс багагүй урттай

Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:



- Хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, факсны дугаар, цахим шуудангийн хаяг, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны нэрийг тусгасан тодорхойлолт;
- Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ, татвар төлөгчийн гэрчилгээ;
- Хуульд заасан шаардлагын дагуу хийгдсэн талбайн зураг ба тухайн зураг дээр тэмдэглэсэн уг талбай байрших аймаг, сум, дүүргийн нэр;
- Үйлчилгээний хөлс төлсөн баримт;
- Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээж авсан Эрдэс баялгийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэр;
- Хайгуулын ажлын явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримт;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;
- Хуульд заасан бусад.



Төрийн захиргааны байгууллага өргөдлийг хүлээн авмагц дор дурдсан ажиллагаа явуулна:

1. өргөдлийг өргөдөл бүртгэх дэвтэрт бүртгэж өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудас тус бүрт бүртгэлийн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх;
2. бүртгэсэн даруйд өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь шаардлагыг хангаж байгаа эсэхэд анхан шатны шүүлт хийх.

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

Шүүлт хийсний дараа дараахь зүйлийг тодруулна:

- 1 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч уг зөвшөөрлөөр олгогдсон талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан бол хүсэлт гаргасан талбай нь хайгуулын талбайн хилийн дотор бүрэн багтаж байгаа эсэх;
- 2 хүсэлт гаргасан талбай нь тусгай хэрэгцээ болон нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай ямар нэгэн байдлаар давхцаж байгаа эсэх;
- 3 хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсч болох экологийн хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэх.

Дээрх үйл ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан дараахь шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

- өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь шаардлагыг хангаагүй бол хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж шалтгаан, үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх;
- хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг ажлын 10 өдрийн хугацаанд төлүүлэх;
- хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй бол уурхайн талбай олгож, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлүүлэх;
- хүсэлтэд дурдсан талбай нь аль нэг хэсэгтэй давхцсан бол ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, шалтгаан үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, энэ тухай өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэх.

Өргөдөл гаргасан этгээд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг заасан хугацаанд хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгож, тусгай зөвшөөрөл болон уурхайн талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.



Ашиглалтын тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигч этгээдийн нэр, хаяг болон уурхайн талбайн булангийн цэгийн солбицлуудыг тэмдэглэх бөгөөд уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тэмдэглэх зориулалт бүхий хавсралттай байна.

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023



Төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 7 өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг даргад энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч гуравдагч этгээдэд үүсмэл ордыг ашиглуулах тохиолдолд уг гуравдагч этгээдтэй үүсмэл орд ашиглах тухай гэрээ байгуулж, энэ гэрээний талаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 14 хоногийн дотор мэдэгдэнэ.

## Тусгай зөвшөөрөлтэй холбогдон гарах зардал

### *i. Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр*

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь **хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг** жил бүр хайгуулын талбайн гектар тутамд дараах байдлаар төлнө:

эхний жил	145 төгрөг
2 дахь жил	290 төгрөг
3 дахь жил	435 төгрөг
4-6 дахь жилд тус бүр	1450 төгрөг
7-9 дахь жилд тус бүр	2175 төгрөг
10-12 дахь жилд	7250 төгрөг

**Хайгуулын ажлын зардлын доод хэмжээ.** Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон тухайн талбайн гектар тутамд дараахь хэмжээнээс багагүй зардал бүхий хайгуулын ажлыг жил бүр хийж гүйцэтгэнэ:

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

тусгай зөвшөөрлийн 2 - 3 дахь жилд	0,5 америк доллар
тусгай зөвшөөрлийн 4 - 6 дахь жилд	1,0 америк доллар
тусгай зөвшөөрлийн 7 - 9 дахь жилд	1,5 америк доллар
тусгай зөвшөөрлийн 10 - 12 дахь жилд	10 америк доллар

## ii. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон уурхайн талбайн гектар тутамд 21750 төгрөг байх бөгөөд харин шохойн чулуу, нүүрс, дотоодын үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын хувьд гектар тутамд 7250 төгрөг байна.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг зөвшөөрөл олгосон тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлнө.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа жилийн төлбөрийг тухайн тусгай зөвшөөрлийг олгосон өдрөөс эхлэн тооцож жил бүр урьдчилан төлөх бөгөөд заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд тухайн жилд төлөх төлбөрийн үнийн дүнгийн 0.3 хувиар тооцон алданги ногдуулна. Уг хугацаа хэтэрсэн хоног 30 хүртэл байх бөгөөд энэ хугацаанаас хэтэрвэл тусгай зөвшөөрлийг цуцална.

## Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох.

Зөвшөөрлийг дараах тохиолдолд гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

- 1** зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
- 2** хуульд заасан мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл буруу гаргасан;
- 3** зөвшөөрөл олгосноос хойш хоёр жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон.

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

Түдгэлзүүлэх мэдэгдлийг авснаас хойш 10 хоногийн дотор зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, баримт бичгийг эрх бүхий этгээдэд ирүүлнэ.

Зөвшөөрлийг дараах тохиолдолд **хүчингүй болгоно**:



- 1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
- 2.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;
- 3.зөвшөөрөл эзэмшигч нийтийн эрх ашиг, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн, их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
- 4.зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн;
- 5.зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан болон бусад хэлбэрээр шилжүүлсэн;
- 6.зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 7.зөвшөөрөл эзэмшигч иргэн бол иргэний эрх зүйн бүрэн чадамжгүйд тооцогдсон, хуулийн этгээд бол дампуурсан, эсхүл татан буугдсан;
- 8.улсын тэмдэгтийн хураамжийг хугацаанд нь төлөөгүй;
- 9.хуульд заасан бусад.

## **Зөвшөөрлийг хүчингүй болгох журам**

- 1** Эрх бүхий этгээд зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байгаа тухай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэнэ.
- 2** Мэдэгдлийг хүлээн авснаас хойш зөвшөөрөл эзэмшигч 30 хоногийн дотор зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг эрх бүхий этгээдэд ирүүлээгүй бол уг хугацаа дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 3** Зөвшөөрөл эзэмшигч заасан хугацаанд тайлбар өгөөгүй, заасан мэдэгдэлд гомдол гаргаагүй бол зөвшөөрөл хүчингүй болгох үндэслэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 4** Эрх бүхий этгээд нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрээ тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяа татварын албанд ажлын 2 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

## **Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосны үр дагавар:**

- 1.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагаатай



# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

холбогдох гэрээний үйлчлэлийг түр зогсоож болно.

2. Зөвшөөрлийг хүчингүй болгосон нь тухайн зөвшөөрөл эзэмшигчээс зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагаатай холбогдуулан бусадтай байгуулсан гэрээг цуцлах үндэслэл болно.

3. Зөвшөөрлийг хүчингүй болгосны улмаас бусдад учруулсан хохирлыг зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд нөхөн төлнө.

4. Зөвшөөрлийг хууль бусаар олгосны улмаас бусдад учирсан хохирлыг тухайн зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан эрх бүхий этгээд болон тухайн асуудал хариуцсан албан тушаалтан, эсхүл эрх шилжүүлэн авсан этгээд нөхөн төлнө.

5. Төрийн албан тушаалтан зөвшөөрөл олгох журмыг зөрчсөн, эсхүл үүрэгт ажилдаа илтэд болгоомжгүй хандсан, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүй, эсхүл үүсч болох хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг арилгана.

6. Эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн зөвшөөрөл эзэмшиж байсан этгээдээс зургаан сарын дотор тухайн зөвшөөрлийг дахин хүссэн өргөдлийг хүлээж авахгүй.

## 2023 оны эхний 8 сарын тусгай зөвшөөрлийн бүртгэлд хийгдсэн өөрчлөлт, тусгай зөвшөөрлийн төрлөөр [5]:



	2021	2022	2023 (1-8 сар)
<b>Шинээр олгосон</b>	163	93	168
Уул уурхай	54	36	13
Хайгуул	0	7	0
Тендер	109	50	155
<b>Эрхээсээ татгалзсан</b>	26	34	15
Уул уурхай	4	12	4
Хайгуул	22	22	11
<b>Цуцлагдсан</b>	75	45	28
Уул уурхай	30	20	16
Хайгуул	45	25	12
<b>Хугацаа дууссан</b>	120	100	13
<b>Шилжүүлсэн</b>	74	63	52
Уул уурхай	16	16	11
Хайгуул	58	47	41
<b>Хугацаа сунгасан</b>	246	291	57

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

## Татвар

Аж ахуйн нэгжийн татвар ногдуулах орлогын хэмжээнээс хамаарч дараах хувь хэмжээний татвар ногдуулдаг.

Татвар ногдуулах орлогын хэмжээ	Татварын хувь
0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого	10%
6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод	25%

Түүнчлэн ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн эцсийн эзэмшигч (30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээд<sup>[1]</sup>) –ийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг “төрийн байгууллагаас олгосон эрх борлуулсан, шилжүүлсний орлого” гэж тооцох бөгөөд 10 хувийн албан татвар ногдуулна.

Ашигт малтмалын нөөц ашигласан аж ахуй нэгжүүд нөөц ашигласны төлбөр төлөх бөгөөд дараах байдлаар төлбөрийг тодорхойлно:

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч	Олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан нүүрсний нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувь, харин бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувь
Ашигт малтмал экспортолсон этгээд	Экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн зах зээлийн үнийг баримтлана
Монгол банк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд	Монгол банк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алтанд ногдох нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 5.0 хувь

[6] Law of Mongolia on General Taxation - <https://legalinfo.mn/mn/detail/14403>

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь аливаа татварын хөнгөлөлт болон чөлөөлөлтийг эдлэхгүй.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу экспортод гаргасан ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнд НӨАТ-ийг "0" хувиар ногдуулдаг. Харин экспортод гаргасан эцсийн бүтээгдэхүүнээс бусад ашигт малтмалын бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлнө.

Үүнээс гадна, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

## Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

Төлбөр ногдох ус	Төлбөрийн хязгаар / экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар			
	Гадаргын усанд		Газрын доорх усанд	
	доод	дээд	доод	дээд
<b>Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:</b>				
<b>а/ ашигт малтмал олборлох, баяжуулах</b>	<b>10</b>	<b>40</b>	<b>20</b>	<b>60</b>
<b>б/ зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах</b>	<b>10</b>	<b>50</b>	<b>20</b>	<b>70</b>
<b>в/ усыг шавхан зайлуулах</b>	<b>10</b>	<b>15</b>	<b>15</b>	<b>50</b>
<b>г/ эрэл, хайгуулын өрөмдлөг хийх</b>	<b>10</b>	<b>30</b>	<b>20</b>	<b>50</b>

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.

## 3. УУЛ УУРХАЙН ТӨСЛҮҮД



“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь зэс, молибдены хүдрийн олборлолт, баяжуулалтаар Ази тивдээ томоохонд тооцогддог үйлдвэр бөгөөд жилд 37 сая тонн хүдэр олборлон, 32.5 сая тонн хүдэр боловсруулж 580.0 орчим мянган тонн зэсийн баяжмал, 5.0 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг.

Монгол Улсын Засгийн газар 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр тогтоол гаргаж, “Эрдэнэт үйлдвэр”-ийг Төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг баталсан. Эрдэнэт үйлдвэр нь Улсын үйлдвэрийн газрын статустай болсонтой уялдуулж, Ерөнхий захирлын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/552 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн удирдлага, менежментийн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, хөгжлийн төлөвлөлтийг хамарсан урт хугацааны “Тогтвортой хөгжлийн бодлого”-ыг баталсан. Энэ хүрээнд Технологийн бодлого, Техникийн бодлого, Эдийн засаг, санхүү бүртгэлийн бодлого, Нийгмийн бодлого, Байгаль орчны бодлого гэсэн тэргүүлэх 5 чиглэлийн хүрээнд 25 зорилт дэвшүүлэн ажиллаж байна.



“Оюу толгой” бол Монгол улсын хамгийн том зэс, алтны компани бөгөөд Монгол улсын Засгийн газар болон “Рио Тинто” компани хоорондын стратегийн түншлэл юм.

Оюу толгойн орд нь зэс, алт, болон мөнгө агуулсан хэд хэдэн хүдрийн биетээс бүрддэг. Хойноосоо урагш нийт 12 км сунан тогтсон хүдрийн биетүүд нь Хюго Дамметтын хойд бүс, Хюго Дамметтын өмнөд бүс, Оюут болон Херуга хүдрийн биет юм. Ил уурхайгаар Оюу толгойн үндсэн гурван ордын нэг болох Өмнөд Оюу ордыг олборлодог. 2012 оны 4 дүгээр сард олборлолт нь эхэлсэн. Өдгөө ил уурхайд өдөрт 100 мянган тонн хүдэр олборлон гаргадаг байна. Оюу толгойн баяжуулах үйлдвэр нь Монголын түүхэн дэх хамгийн том үйлдвэр юм. 2013 оны 2 дугаар сарын 1-нд анхны зэсийн баяжмалаа үйлдвэрлэж, мөн оны 7 дугаар сарын 9-нд экспортод гаргасан. Баяжуулах үйлдвэр хоногт 100,000 тонн хүртэл хүдэр боловсруулах хүчин чадалтай. Оюу толгойн бүлэг ордын нийт нөөцийн 80 гаруй хувь буюу хамгийн агуулга сайтай хүдэр нь газрын гүнд оршдог. Газрын гадаргаас олон зуун метрийн гүнд буй эдгээр хүдрийн биет нь зэс, алтны агуулгаараа дэлхийд томоохонд тооцогддог. Гүний уурхайгаас олборлох хүдэр дунджаар 1.66 хувийн зэсийн агуулгатай.

Оюу толгой уурхай үйлдвэрлэлийн оргил үедээ буюу 2028-2036 онд ил болон гүний уурхайгаас жилд дунджаар 480000 тонн зэс олборлож, Ингэснээр 2030 он гэхэд дэлхийд дөрөвт орох зэсийн уурхай болох төлөвтэй байна.

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023



“Энержи Ресурс” ХХК нь 2005 онд байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай уул уурхайн компани бөгөөд Монголын уул уурхайн салбарт тэргүүлэгч аж ахуйн нэгжүүдийн нэг юм. Тус компанийг М-Си-Эс групп, Петровис ХХК, Шунхлай групп зэрэг үндэсний хэмжээний томоохон компаниудын хамтын хөрөнгө оруулалттайгаар байгуулсан. 2010 онд Энержи Ресурс компани Хонконгийн хөрөнгийн биржид бүртгүүлж, Монголын үндэсний компаниудаас анх удаа олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа амжилттай гаргасан.

Тус компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа худаг коксжих нүүрсний ордод үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2,962 га талбай бүхий, 11952А ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Ухаа худаг уурхайн үйл ажиллагаа 2009 онд эхэлсэн. Үүнээс хойш ердөө 2-3 жилийн хугацаанд тус уурхай нь Нүүрс баяжуулах үйлдвэр, 18 мегаваттын цахилгаан станц, усан хангамжийн систем, орон сууцны хороолол, сургууль, цэцэрлэгийн цогцолбор гээд техникийн болон нийгмийн дэд бүтцүүдтэй, дэлхийн жишигт нийцсэн, аж үйлдвэрийн томоохон цогцолбор болон хөгжсөн



“Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Ашигт малтмалын тухай” хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр ажилладаг.

“Эрдэнэс Тавантолгой” төсөл нь нүүрс олборлолт, бүтээгдэхүүн боловсруулах, дэд бүтэц, үйлдвэрүүдийг барьж байгуулах, ус хангамжийн системийг байгуулах, ордод нэмэлт хайгуул, судалгаа хийх, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд хүргэх, дотоодын болон олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаа арилжаалах гэсэн үндсэн чиглэлээр хэрэгждэг.



# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

ГЕОЛОГИЙН СУДАЛГАА, ХАЙГУУЛ		2022	
		Сонгон шалгаруулалт /тендер/	~2 сая га
ЭКСПОРТ		2022	
Зэс	 	Зэсийн баяжмал Катодын зэс	1.5 сая тн 9.8 мян.тн
Нүүрс	 	Металлургийн нүүрс Баяжуулсан нүүрс	31.8 сая тн 11.4%
Алт	Алт олборлолт (Монголбанк)	Алт	22.9 тн
ДОТООД ХЭРЭГЛЭЭ		2022	
Газрын тос		Газрын тосны бүтээгдэхүүн	1.72 сая тн / импортлосон/

## 4. ТЕНДЕРИЙН БАГЦУУД

Өнөөгийн байдлаар газрын тосны 13 нээлттэй хайгуулын талбай, 9 Бүтээгдэхүүн хуваах гэрээт (БХГ) хайгуулын талбай, 4 ашиглалтын талбай, 6 нүүрсний давхаргын метан хийн БХГ-т талбайд гадаад, дотоодын гэрээлэгч компаниуд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. **Нялга XVI:** 691.4 тууш км<sup>2</sup> хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуулын 2, усны 2 цооног өрөмдөж \$14.8 саяыг зарцуулсан бөгөөд 1 цооногт тосны шинж тэмдэг илэрсэн.
2. **Сүхбаатар XXVII:** 23047 км<sup>2</sup> талбайд геологийн зураглал, 5,777 ф.цэгт хүндийн хүчний судалгаа, 11,020 тууш км соронзон хайгуул, 453.1 тууш км<sup>2</sup> хэмжээст чичирхийллийн судалгаа хийж \$4.44 саяыг зарцуулсан.
3. **Хөхнуур XVIII:** 2,662 ф.цэгт хүндийн хүчний судалгаа, 9,861 км<sup>2</sup> талбайд 5,470 ф.цэгт соронзон хайгуул, 2,408.2 тууш км<sup>2</sup> хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуулын 5 цооног өрөмдснөөс 3 цооногт тосны шинж тэмдэг илэрсэн. 3 цооногт туршилт хийж 32 тн тос олборлож \$24.87 саяыг зарцуулсан.
4. **Баянхошуу XXII:** 2,345.12 т.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа, хайгуулын 8 цооног өрөмдснөөс 4 цооногт тосны шинж тэмдэг илэрсэн \$25 саяыг зарцуулсан.
5. **Зүүнбаян XIV:** 3,512 ф.цэгт хүндийн хүч, 1,155.7 т.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа хийж \$4.9 саяыг зарцуулсан.
6. **Цагаан элс XIII:** 1,779 ф.цэгт хүндийн хүч, 790.6 т.км хоёр хэмжээст чичирхийлэл, хайгуулын 2 цооног өрөмдөж \$7.5 саяыг зарцуулсан.
7. **Төхөм X (хойд):** 5,165 ф.цэгт хүндийн хүч, 1,130.9 т.км хоёр хэмжээст чичирхийлэл, 55,242 ф.цэгт соронзон судалгаа, хайгуулын 2 цооног өрөмдөж \$9.2 саяыг зарцуулсан.

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

Мөн одоогоор Хар ус II, Шарга III, Нэмэгт VI, Хонгор VIII, Чойр XXV зэрэг талбайнуудад суурь судалгааны ажил хийгдсэн байна.

*Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарлагдсан талбайнууд*

№	Нэр	Байршил	Хэмжээ
1	Хөндий	Өвөрхангай аймгийн Тарагт сум	8,917.44 га
2	Өлзийт	Өвөрхангай аймгийн Тарагт сум	13,106.83 га
3	Мөнхтэй	Дундговь аймгийн Адаацаг, Сайнцагаан сум	1,819.51 га
4	Бүргэдтэйн гол	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум	661.4 га
5	Ишгэн уул	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум	9,839.75 га
6	Баясгалант уул	Булган аймгийн Гурван булаг сум	4,014.8 га
7	Таван хайрхан	Ховд аймгийн Буянт сум	5,161.34 га
8	Улаан уул	Баян-Өлгий аймгийн Толбо сум	2,506.57 га
9	Баруун өндөр	Хэнтий аймгийн Баян-Адрага, Биндэр сум	4344.83 га
10	Модон салаа	Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Улаанхус сум	4537.05 га
11	Тошингийн уул	Баян-Өлгий аймгийн Сагсай, Буянт сум	10122.03 га
12	Хайчийн булаг	Увс аймгийн Өмнөговь сум	3937.62 га
13	Хөндий	Ховд аймгийн Алтай сум	869.6 га
14	Хуурай салаа	Баян-Өлгий аймгийн Булган сум	1301.73 га
15	Морьт уул	Ховд аймгийн Манхан, Зэрэг сум	8335.54 га
16	Баян худаг	Говь-Алтай аймгийн Хөхморьт сум	399 га
17	Хар хөвийн худаг	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум	6892.75 га
18	Ёлхийн уул	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум	10272.07 га
19	Шийр уул	Хэнтий аймгийн Баян-Адрага сум	9645.28 га
20	Шинэ усны сарьдаг	Увс аймгийн Өлгий сум	10751.34 га
21	Гурван шовгор	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум	5639.57 га
22	Дөшийн булаг	Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум	3044.87 га
23	Асгат уул	Завхан аймгийн Асгат, Баянхайрхан сум	1627.88 га
24	Баруун цагаан нуур	Баян-Өлгий аймгийн Ногооннуур сум	1286.4 га
25	Хоо толгой	Увс аймгийн Малчин сум	411.1 га

# МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

## ЭХ СУРВАЛЖ:

1. Татварын ерөнхий хууль - <https://legalinfo.mn/mn/detail/14403>
2. Зөвшөөрлийн тухай хууль - <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530780109311>
3. Ашигт малтмалын тухай хууль - <https://legalinfo.mn/mn/detail/63>
4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/9750>
5. Газрын тосны тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/10484>
6. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/10484>
7. Цөмийн энергийн тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/97>
8. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль - <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8663>
9. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль - <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532653439101>
10. Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 06 сарын 07-ны өдрийн 223 тоот тогтоол - “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай” <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759591005431>
11. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал - <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210470&showType=1>
12. Ашигт малтмал ба газрын тосны статистик 2023/08 - <https://mrapam.gov.mn/public/pages/196/2023.08.stat.report.eng.pdf>
13. ДНБ - ий 2023 оны эхний хагас жилийн танилцуулга - <https://www.1212.mn/mn/statistic/statcate/573052/report/573052>
14. Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл /2023 оны 1-7 сар/ - <https://mmhi.gov.mn/2023/09/25/%d1%8d%d1%80%d0%b4%d1%8d%d1%81-%d0%b1%d0%b0%d1%8f%d0%bb%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d1%81%d0%b0%d0%bb%d0%b1%d0%b0%d1%80%d1%8b%d0%bd-%d1%81%d1%82%d0%b0%d1%82%d0%b8%d1%81%d1%82%d0%b8%d0%ba-%d0%bc%d1%8d-17/>
15. Сонгон шалгаруулалтын 64-18-ын урилга /цахим хуудас/ - <https://mrapam.gov.mn/public/pages/132/%D0%A1%D0%A864-18.pdf>
16. <https://investmongolia.gov.mn/metals-and-mining/>



## МОНГОЛЫН УУЛ УУРХАЙ - 2023

**Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл асуулт байвал Грата Интернэшнл хуулийн фирмийн Партнер В.Болормаагийн [bvolodya@gratanet.com](mailto:bvolodya@gratanet.com) болон эрх зүйч С.Анугийн [asaikhnaa@gratanet.com](mailto:asaikhnaa@gratanet.com) хаягаар эсвэл +976 70155031 утсаар холбоо барина уу.**

Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм Грата Интернэшнлийн Монгол дах оффис болох Өмгөөллийн “Грата Интернэшнл Монголиа” ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэн хүргэв. Энэхүү хуулийн зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудалд нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Иймд уншигч нь ямар нэгэн үйлдэл хийх/эс хийхээс өмнө өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.



## About GRATA International

GRATA International is a dynamically developing international law firm which provides services for projects in the countries of the former Soviet Union and Eastern Europe: full coverage of the entire region with network of offices, highly qualified team of professionals suited for cross-border projects. Firm's reputation and expertise are confirmed by testimonials from transnational clients and leading international ratings.

A wide network of office operating under one system and platform delivers great convenience for our clients. Any office can act as a "one-stop-shop" for its clients and provide them with access to services in other cities and countries. If necessary, inter-office teams with relevant experience are assembled to provide solutions to complex tasks. Service quality is assured by a clear system of organisation of this process.

GRATA International is present in the following jurisdictions: Armenia (Yerevan), Azerbaijan (Baku), Belarus (Minsk), Cyprus (Limassol), Georgia (Tbilisi), Kazakhstan (Aktau, Almaty, Atyrau, Astana, and other cities), Kyrgyz Republic (Bishkek), Moldova (Chisinau), Mongolia (Ulaanbaatar), Russia (Moscow, St. Petersburg, Rostov-on-Don, Samara), Tajikistan (Dushanbe), Turkmenistan (Ashgabat), Turkey (Istanbul), UAE (Dubai), Ukraine (Kyiv) and Uzbekistan (Tashkent).

In addition to its offices, GRATA International has representatives in the UK (London), Germany (Frankfurt), the USA (New York), China (Beijing), Switzerland (Zurich).

**GRATA International is regularly acclaimed by leading international rankings: Chambers Global, Chambers Asia-Pacific, Legal 500, IFLR1000, WWL, Asialaw Profiles, and is featured in Deals of the Year Awards by China Business Law Journal.**

### Key Industry Sectors:

- Banking & Finance
- Construction & Infrastructure
- Industry & Trade
- Mining
- Oil & Gas
- Pharmaceuticals & Healthcare
- Technology, Media & Telecommunications
- Transport



> 22

countries of presence



> 32

years of experience




> 225

professionals




> 15

practice areas



14 400+

clients



36 700+

projects



# Global Presence



## Integrated Offices

**Azerbaijan**  
Baku

**Kyrgyzstan**  
Bishkek

**Tajikistan**  
Dushanbe

**Belarus**  
Minsk

**Moldova**  
Chisinau

**Ukraine**  
Kyiv

**Georgia**  
Tbilisi

**Mongolia**  
Ulaanbaatar

**Uzbekistan**  
Tashkent

**Kazakhstan**  
Astana  
Almaty  
Atyrau  
Aktau, etc.

**Russia**  
Moscow  
Rostov-on-Don  
St. Petersburg

**Armenia**  
Yerevan



## Associate Offices

**Cyprus**  
Limassol

**Russia**  
Samara

**Turkmenistan**  
Ashgabat

**Turkey**  
Istanbul

**UAE**  
Dubai



## Representatives

**China**  
Beijing

**Germany**  
Frankfurt

**Switzerland**  
Zurich

**UK**  
London

**USA**  
New York